



## Даатгалын нөхцөл

Та даатгалын нөхцөлтэй танилцана уу

**Даатгалын зүйл:** Гадаадад зорчигчдын гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал.

**Даатгалын үнэлгээ:** Бүс нутгаас хамааран 50,000\$, 30,000\$ сонголттой байна.

	ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТЫН БҮС	ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ	
1	Шенген	\$50,000	
2	Ази (Япон орно)	\$50,000	\$30,000
3	Дэлхий дахинд	\$50,000	
4	Дэлхий дахинд (АНУ, Канад орохгүй)	\$50,000	\$30,000

ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ		
Ханаарах эрсдэл		Хамгаалалт
1	Гадаад оронд байх хугацаанд гарах эмнэлэг, эмчилгээний зардал	Үнэлгээ хүртэл Хариуцах хэсэг - \$50
2	Даатгуулагч аяллын явцад гэнэт өвдөх, гэнэтийн осолд орсон тохиолдолд нутаг оронд хүргэх, тээвэрлэх.	\$10,000
3	Шүдний яаралтай эмчилгээ	\$450 Хариуцах хэсэг - \$50
4	Даатгуулагчтай хамт яваа гэр бүлийн гишүүнийг яаралтай буцаах	\$10,000
5	Шарил зөөн тээвэрлэх	\$10,000
6	Гэр бүлийн нэг гишүүний зардал	1 хоногийн дээд хязгаар - \$85 Нийт хязгаар - \$850
7	Гэр бүлийн гишүүдээс нас барсан тохиолдолд Даатгуулагчийг яаралтай нутаг орон руу нь буцаах зардал	\$10,000
8	Эм тариа хүргэх үйлчилгээ	\$10,000
9	Яаралтай мэдээ дамжуулах үйлчилгээ	\$10,000
10	Батлан даалтын барьцааны урьдчилгаа	\$850
11	Бэлэн мөнгө алдсаны улмаас төлбөр тооцоо хийх боломжгүй болох үед мөнгө зээлдүүлэх	\$850
12	Хуулийн зардал	\$2,100
13	Гадаадад паспорт, жолооны үнэмлэх, бичиг баримтаа хаяж гээгдүүлэх	\$200
14	Ачаа тээш алдагдах	\$210
15	Ачаа тээш хоцрох	\$100
16	Алдагдсан ачаа тээш болон хувийн эд зүйлсийн байгаа газрыг тодорхойлох болон тээвэрлэн хүргэх	\$10,000
17	Нислэг хойшлогдох	\$180
Ковид-19-ийн хамгаалалт		

## НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ НӨХЦӨЛ

- Шуурхай албаны 1800-1889 дугаар луу нэн даруй холбогдон мэдэгдэх
- Тэнгэр даатгал ХХК-аас нөхөн төлбөрийн маягтыг авч бөглөх
- Нөхөн төлбөрийн маягтыг нэхэмжлэл болон аяллын бусад холбогдох бичиг баримтуудын хамт Тэнгэр даатгал ХХК-д өгнө үү. Хэрвээ эмчилгээ хийлгэсэн бол гэмтэл, өвчний төрлийг тодорхойлсон эмчилгээний болон төлбөр хийсэн бол төлбөрийн баримтуудыг Тэнгэр даатгал ХХК-д бас ирүүлнэ үү.
- Та эдгээр бичиг баримтуудаа нутагтаа буцаж ирсэнээс хойш 31 хоногийн дотор бүрдүүлж өгөх үүрэгтэй. Нөхөн төлбөр авахад Цагдаагийн байгууллагын тодорхойлолт, бичиг баримт шаардлагатай бол үүнийг даатгалын тохиолдол болсон өдрөөс 24 цагийн дотор ирүүлнэ үү.

## НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХГҮЙ НӨХЦӨЛ

**Даатгагч нөхөн төлбөр олгохгүй. Үүнд:**

- Даатгуулагчийн өөрийн буруутай үйл ажиллагаа, гэмт хэргийн чанартай үйлдэлд оролцсон эсвэл санамсар болгоомжгүй, хайхрамжгүй үйлдлийн шууд болон шууд бус хохирол. Даатгуулагчийн сэтгэл санааны гутрал, сэтгэцийн гажиг, сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийлгэх үеийн үйлдэл, түүний үр дагавар.
- Үер, газар хөдлөлт, хөрсний нуралт, галт уулын дэлбэрэлт, хүчит салхи, агаарын хөлөг эсвэл агаараас унах биет зүйлс, агаар мандлын, цаг уурын, газар хөдлөлтийн болон геологийн гэх мэт байгалийн онцгой үзэгдэл.
- Терроризмын үйл ажиллагаа, бослого, үймээн самуун болон олон нийтийн үйл ажиллагаа, цугларалтаас үүдсэн хохирол.
- Энхийн цагт цэрэг армийн болон хамгаалалтын хүчний үйлдэл, хохирол.
- Зарласан болон зарлаагүй дайн байлдааны үйл ажиллагаа, олон улсын хөндлөнгөөс оролцон хүч хэрэглэсэн үйл ажиллагаа, мөргөлдөөн, маргаантай асуудал.
- Радио идэвхт болон цөмийн эрчим хүчний нөлөөлөл.
- Даатгуулагчийн аргагүй эсвэл шаардлагатай хамгаалалтаас бусад тохиолдолд хэрүүл шуугиан тарих, аливаад уриалан дуудсан үйлдэл хийх, мөрийцөх зэргээс үүдсэн хохирол.
- Нэмэлт хураамж төлж, гэрээнд тусгайлан тохиролцоогүй нөхцөлд Даатгуулагч даатгуулахаас өмнө өвдөж байсан болон гэнэтийн осолд орж байсан тохиолдол.
- Даатгуулагч уралдаан тэмцээн, спортын арга хэмжээ болон дадлага, туршилт болон бэлтгэлд оролцсон.
- Автомашин, мотоцикл бусад ижил төстэй тээврийн хэрэгслийн уралдаан тэмцээнд оролцох, ан хийх, усанд шумбах, хүн тээвэрлэх, зориулалтын бус тээврийн хэрэгслээр олон улсын далай тэнгист навигацийн тээвэр хийх, морь унах, ууланд авирах, бокс тоглох, барилдах, цэргийн урлаг болон шүхрээр буух, халуун агаар бүхий агаарын бөмбөлөгөөр нисэх, чөлөөт уналт, гулгалт зэрэг аюултай спортын төрөлд оролцох.
- Спортын холбоо болон ижил төстэй байгууллагуудаас зохион байгуулж байгаа уралдаан тэмцээнд оролцох.
- Цанаар гулгах болон түүнтэй төстэй спорт, өвлийн болон зуны спортын аюултай төрөлд оролцох.
- Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна амьдрах байнгын оршин суугч болон оюутан.
- Иргэний агаарын хөлгөө бусад агаарын хөлөг болон нисдэг тэргээр зорчих эсвэл багийн гишүүнээр аялах.
- Даатгуулагчийн ажил үйлчилгээний үр дагавараас үүдэлтэй гарсан хохирол, ажлын байран дахь осол.
- Зүрх судас болон цусны эргэлтийн эмгэг, түүний үр дагавартай шууд болон шууд бусаар холбоотой аливаа эмчилгээ.

**Дараах тохиолдолд Даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзах эрхтэй. Үүнд:**

- Нэн яаралтай, зайлшгүй тохиолдлоос бусад тохиолдолд .....-д урьдчилан мэдэгдэлгүйгээр, эсвэл уг байгууллагын албан ёсны зөвшөөрөлгүйгээр Даатгуулагчийн өмнөөс үзүүлсэн аливаа үйлчилгээ. Хэрэв нэн яаралтай болон зайлшгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэх шаардлага гарсан бол Даатгагчид холбогдох баримт, тооцоо, нэхэмжлэлийн эх баримтыг бүрдүүлж ирүүлэх шаардлагатай.
- Аливаа архаг хууч эсвэл даатгуулахаас өмнө өвдөж байсан өвчнөөс үүдэлтэй эмгэг, гэмтэл.
- Амиа хорлох, амиа хорлох үйлдэл хийснээс биед учирсан гэмтэл.
- Архи, хар тамхи, хортой бодис, мансууруулах бодис, эмчийн жоргүй эм тариаг дур мэдэн хэрэглэснээс мөн түүнчлэн сэтгэцийн өвчин, мэдрэлийн тэнцвэргүй байдлаас үүдсэн өвчин эмгэг.
- Даатгагчийн эмч мэргэжилтнүүдийн зөвшөөрсөн тохиолдолд Даатгагчийн санал болгосон шилжүүлэх, тээвэрлэх асуудлыг Даатгуулагч болон түүнийг төлөөлж буй хүмүүс татгалзсан, хойшлуулсан.
- Нөхөн сэргээх эмчилгээ
- Протез (хиймэл эрхтэн), ортопед, остесинтез материал, нүдний шил.
- Жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт, тэдгээрийн үр дагавар.
- Баглаа боодол, ачааны таних тэмдэг хангалтгүй байх, мөн амархан мууддаг эд зүйлс болон хэврэг ачаа тээш.

**Даатгуулагч аяллаа эхэлснээс хойш дараах тохиолдолд даатгалын үйлчилгээ болон нөхөн төлбөр олгогдохгүй. Үүнд:**

- Даатгалын гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанаас өмнө учирсан тохиолдол.
- Эмнэлэгийн тусалцаа, эмчилгээ авах зорилготойгоор гадаад оронд зорчсон.
- Үхэлд хүргэх өвчний онош тогтоогдсоны дараа гадаад оронд зорчсон.
- Гадаад оронд зорчихоос өмнөх 12 сарын дотор Даатгуулагч эмчилгээ хийлгэж байсан, эмнэлэгийн хяналтанд байсан үедээ эмчийн зөвшөөрөлгүйгээр зорчсон.
- Даатгуулагч байнгын оршин суугаа газартаа байх хугацаанд гарсан зардал, даатгалын хамгаалалтын хязгаараас давсан зардал, даатгалын хугацаа дууссан эсвэл гадаад оронд зорчсоноос хойш 90 хоногийн дараа гарсан зардал.
- Давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү гэрээнд тусгасан үйлчилгээг үзүүлэх боломжгүй бол Даатгагч хариуцлага үүрэхгүй.
- Өмнө нь өвчилж байсан өвчин - Даатгуулахаас 24 сарын өмнө Даатгуулагч аль нэг өвчний улмаас эмчид үзүүлэх, эмчилгээ авах, эм тариа хэрэглэж байсан өвчнийг хэлнэ. Даатгалын гэрээний хугацаанд жилдээ олон удаа аялах тохиолдолд тухайн аялал бүр эхлэхээс 24 сарын өмнө эмчилгээ болон эрүүл мэндийн зөвлөгөө авах эсвэл эм тариа хэрэглэж байсан бол мөн адил хамаарна.
- 70-аас дээш насны Даатгуулагчид - 70-аас дээш насны Даатгуулагчдын эмнэлэгийн дүгнэлтэнд бичигдсэн өмнө нь өвчилж байсан аливаа өвчнийг энэхүү даатгалаар хамгаалахгүй. 70-аас дээш насны Даатгуулагчдын цусны даралт, чихрийн шижин өвчин зэрэг зүрх судастай холбоотой аливаа өвчнийг энэхүү даатгалаар хамгаалахгүй.